



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.07.05

№

ЗГ-1/М

танай

-ны №

-т

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Монгол-Хятадын 1955 оны Хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

do 13. 07. 05 № ХТ/1644
танай _____-ны № _____-т

**Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

“Монгол-Хятадын 1955 оны Хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ^{д/} хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлд:

“XXXIX.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол-Хятадын 1955 оны Хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол-Хятадын 1955 оны Хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.07.05 № 1/3778
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

“Монгол-Хятадын 1955 оны Хилийн төмөр
замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод
хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай
холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8
дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн
мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

1516034.1
А5 Файл.2023



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

᠒᠐᠒3.07.᠒5 № 01/5137

танай _____-ны № _____-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА**

“Монгол-Хятадын 1955 оны Хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001541

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

**МОНГОЛ-ХЯТАДЫН 1955 ОНЫ “ХИЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ХЭЛЭЛЦЭЭР”
БОЛОН “ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ ДАМНАСАН
ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙГООР АВАХ ЗАРИМ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Найм дахь зорилтын 8.1-д “Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан. Энэ хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 8.1.3-т “Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон дараах чиглэлийн төмөр замуудыг барьж, байгуулна” гэж, 8.1.8-д “Хавирга, Гашуунсухайт, Шивээ хүрэн, Булган, Боршоо, Арц суурь, Бага Илэнхи зэрэг хилийн боомтуудын нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Дөрөв дэх зорилтод “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.” гэж, Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе шатын хүрээнд 2021-2030 онд “Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байх” зорилтыг дэвшүүлсэн байна. Энэ хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.13-т “Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.6-д “Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна,” гэж, 3.2-т “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг

хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ” гэж Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, “Үндэсний төмөр замын сүлжээг өргөтгөж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлж, Баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж тус тус заасан.

1.2.Практик шаардлага

1.Бүгд Найрамдах Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд “Хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг 1955 онд байгуулсан бөгөөд хэлэлцээрийн хүрээнд хилийн өртөөг ганцхан Замын-Үүд-Эрээн байхаар тогтоож хэлэлцээрийн хүрээнд өнөөдрийг хүртэл Замын-Үүд-Эрээн төмөр замын боомтыг ашиглаж ирсэн.

Уг хэлэлцээрт гал тэрэгний хөдөлгөөний нөхцөл, ачаа тээврийн төлөвлөгөө тохиролцох журам, ачаа тээвэрлэлт, зорчигч тээвэрлэлт, талуудын хариуцлага зэрэг зарим зарчмын асуудлыг тусгасан боловч хэлэлцээр байгуулагдсанаас хойш 70 орчим жил өнгөрсөн байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээрийг 2004 онд байгуулсан. Энэхүү хэлэлцээрийн дагуу Монгол-Хятадын хилийн хэсэгт Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч хилийн боомтуудад төмөр замын хилийн боомт ажиллахаар тогтсон боловч хэлэлцээр байгуулагдсанаас хойш төмөр замын хилийн холболт, боомтын ажлууд хэрэгжээгүй байна. Тодруулбал Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Мөн хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас 2012 онд Ганцмод боомт хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хийж дууссан. Уг төмөр замын 92 хувийг Чайна Энержи компани, 6 хувийг Чалко /Aluminum Corporation of China Limited/, 2 хувийг бусад хуулийн этгээд эзэмшдэг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчийн оролцоотой компаниудын эзэмшлийн хувь, хэмжээ их, тодруулбал Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас ихээхэн анхаарал, ач холбогдол өгсөн боловч Монгол Улсын талаас өнөөдрийг

¹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (1992), №1

хүртэл төмөр замыг барьж, байгуулах ажил бүрэн хэрэгжиж дуусаагүй, холболт хэрхэн хийгдэх нь тодорхойгүй байна.

Түүнчлэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас Сэхээ, Зүүнхатавч боомтууд ч Монгол Улсын төмөр замтай холбогдоход бэлэн болсон байна.

2.Түүнчлэн "Шинэ сэргэлтийн бодлого"-д тодорхойлсноор Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлын нэг нь боомтуудын үйл ажиллагааны тогтвортой бус байдал юм.

Экпортын голлох бүтээгдэхүүн болох уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд авто болон төмөр зам, боомтуудын хүчин чадал, гаалиар нэвтрэх тоо, боомт хооронд зарцуулах хугацаа чухал үүрэгтэй. Боомт болон уурхайг холбосон тээврийн сүлжээ нь уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний гарцад шууд нөлөө үзүүлж байна.

Худалдааны голлох боомтуудын нийт импортын бараа, бүтээгдэхүүний 70.1 хувь Улаанбаатар-Замын-Үүд боомтоор хийгдэж байгаа нь боомтууд дээр ачааны бөөгнөрөл, төвлөрөл бий болж, экспортын алдагдсан боломжийг нэмэгдүүлж байна. Мөн гадаад, дотоодын зах зээлд холбогдох тээвэр, логистикийн хүртээмж, зардал нь эдийн засгийн өсөлтийг хязгаарласан хэвээр байна.

Тухайлбал, БНХАУ-ын XIV таван жилийн төлөвлөгөөнд "Хил залгаа орнуудтай харилцаж буй боомтуудын бүтээн байгуулалт болон хөгжлийг бэхжүүлэх" ажлыг идэвхтэй урагшлуулахаар тусгасны дотор Монгол Улстай хиллэдэг Сэхээ, Ганцмод, Эрээн, Мандал, Зүүнхатавч боомтууд багтсан байна. Мөн нүүрсний нийт хэрэглээгээ 2050 он гэхэд 2.3 дахин бууруулахаар төлөвлөж байгаа ч эрчим хүчний нүүрсний импортыг түлхүү бууруулахаар төлөвлөсөн тул манай улсын коксжих нүүрсний экспортын зах зээл хэвээр хадгалагдахаар байна. Түүнчлэн, дэлхий даяар 2020 онд 1.9 тэрбум тонн ган үйлдвэрлэсний 57 хувийг БНХАУ дангаараа үйлдвэрлэж байгаа нь манай улс гол зах зээлд ойр болохыг илтгэдэг.

Иймд боомтуудыг өргөтгөн шинэчлэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Боомтуудыг өргөтгөн шинэчилснээр боомтуудын ачаа нэвтрүүлэх одоогийн хүчин чадал болох 50 гаруй сая.тн байгааг 3 дахин нэмэгдүүлэн 160 сая.тн-д хүргэх, боомтууд дээрх хилийн хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, нэгдмэл удирдлагад оруулж, цахимжуулах замаар бүтээгдэхүүний хилийн хяналтад зарцуулах хугацааг 40 хувиар бууруулах, гаалийн хяналт бүрдүүлэлт, лабораторийн үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлснээр бизнес эрхлэгчдийн экспортод зарцуулах хугацааг нийтдээ 53 хувиар бууруулах тооцоолол гарсан байна.

3.Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор Төмөр замын сүлжээний II дугаар шатанд барьж эхлэх төмөр замын чиглэлд "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийг заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолоор Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай баталж, "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төслийг шуурхай эхлүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

4.Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо "Гашуунсухайт-Ганцмод

боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын "санамж бичиг"-ийг 2022 онд үзэглэсэн.

Энэхүү санамж бичгийн хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК, "Чайна энерги" компанийн хооронд Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрийг байгуулсан. Монгол Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит "Чайна энерги" компанитай удаа дараа яриа хэлэлцээрийг хийсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Энэ хүрээнд экспортыг дэмжих, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, тээврийн зардлыг бууруулах, байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой гэрээг байгуулах эрхийг Засгийн газарт олгох асуудлыг Монгол Улсын Их Хурлын тогтоолоор шийдвэрлэх шаардлагатай байна.

5.Тавантолгой орд нь хатуу коксжих, хагас зөөлөн коксжих, эрчим хүчний шинж чанартай нийт 13 төрлийн нүүрсний давхраастай байх бөгөөд боловсруулалт шаардлагагүй, зах зээлд шууд борлуулах боломжтой сайн чанарын хатуу коксжих 3 болон 4-р давхраасуудад голлон олборлолтыг хийсээр ирсэн байна.

Ашиглалтын хугацаанд нийт олборлосон нүүрсний 92.3%-г 3 болон 4-р давхраас эзэлж байна. Тодруулбал ордын нөөцийг 90 орчим хувийг өнөөдрийг хүртэл сорчлон ашиглаж иржээ.

Цанхийн баруун болон зүүн уурхайн техник эдийн засгийн үндэслэлд 2014 болон 2015 онуудад нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж ордын нөөцийг бүрэн ашиглаж, баяжуулсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн байдаг боловч өнөөг хүртэл ашиглалтад ороогүй байна.

Техник эдийн засгийн үндэслэлээр төлөвлөгдсөн баяжуулах үйлдвэр ашиглалтад ороогүйгээс улбаалан ордын нөөцийг иж бүрэн ашиглах, боловсруулалт, баяжуулалт шаардлагатай муу болон дундаж чанарын нүүрсийг олборлох боломжгүй.

Цаашид ордын нөөцийг сорчлон ашигласнаар Тавантолгойн орд газрын ашиглалтын хугацаа богиносож, эдийн засгийн үр өгөөж буурах эрсдэлд хүрнэ.

2018 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан Тавантолгой ордын нөөцийн хэмжээ 6.3 тэрбум тонн бөгөөд үүнээс 2.55 тэрбум тонн буюу 40 хувь нь 1200-аас доош метрийн гүнд, ил аргаар ашиглах боломжгүй юм.

Энэхүү ил аргаар ашиглах боломжгүй хэсэгт нөөцийг далд аргаар буюу лонгволл технологиор олборлох боломжтой нь тодорхойлогдсон бөгөөд баяжуулах үйлдвэр ашиглалтад оруулах, далд аргаар олборлох технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөлд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судлах, “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Төмөр замын хилийн боомтын холболтын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн болон барилга байгууламжийг цогцоор нь барих ажлыг эрчимжүүлэх, нүүрсний ордыг иж бүрэн ашиглаж, эдийн засгийн үр өгөөж, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх зэрэг зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгах зохицуулалт болон уг тогтоолын хэрэгжилтийг танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Тогтоолын төсөл батлагдснаар дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

Бүгд Найрамдах Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд 1955 онд байгуулсан “Хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулснаар Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч төмөр замын хилийн боомтуудыг холбох эрх зүйн үндэс бүрдэнэ.

Хил дамнасан төмөр зам баригдсанаар Тавантолгойн бүлэг ордын үнэ цэнэ өсөх, тээврийн өртөг зардал буурах, уул уурхайн бүтээгдэхүүнийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар тээвэрлэх, төсвийн орлого, валютын нөөцийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Дөрөв.Тогтоолын төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулна.

Тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж байхгүй болно.

-----oOo-----

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Монгол-Хятадын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 109 дүгээр захирамжаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн болон барилга байгууламжийг цогцоор нь барих ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг чиг үүргийн хүрээнд “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17-д заасан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөлд хамаарах тул хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа болон үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх шаардлагагүй болно.

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэх, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгаж, хэрэгжилтийг танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг тусгалаа.

Тогтоолын төсөлд тусгасан зарчмын шинжтэй дараах арга хэмжээг тусгасан болно. Үүнд:

1.Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах;

2.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд бусад боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалт, хил холболтыг эрчимжүүлэх;

3.Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит

компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК санхүүжүүлэх;

4.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод төмөр замын өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компани болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд үе шаттай жил бүр 20 сая тонн хүртэлх нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацааны худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх;

5.Энэ тогтоолын дагуу байгуулах аливаа гэрээг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөл(off-take)-өөр байгуулахгүй байх;

6.Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бусад уул уурхайн болон уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг тээвэрлэх боломжийг бүрдүүлэх;

7.Энэ заалтын 3, 4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах;

8.Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор газар ашиглах асуудлыг шуурхай шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах.

Тогтоолын төсөл батлагдсанаар Бүгд Найрамдах Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд 1955 онд байгуулсан “Хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулснаар Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч төмөр замын хилийн боомтуудыг холбох эрх зүйн үндэс бүрдэнэ.

Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам баригдсанаар Тавантолгойн бүлэг ордын үнэ цэнэ өсөх, тээврийн өртөг зардал буурах, уул уурхайн бүтээгдэхүүнийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар тээвэрлэх, төсвийн орлого, валютын нөөцийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Түүнчлэн Тогтоолын төсөлд төрийн захиргааны төв байгууллагууд, бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын саналыг албан ёсоор авч төсөлд тусгасан болно. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны www.mojha.gov.mn албан ёсны цахим хуудаст байршуулан иргэд, олон нийт судалж, танилцан, санал өгөх бололцоогоор ханган ажиллаж байна.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Монгол-Хятадын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, байгуулна.” гэж, “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, “Үндэсний төмөр замын сүлжээг өргөтгөж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлж, Баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Тогтоолын төсөлд тусгасан арга хэмжээний үндэслэл, шаардлагын тухайд:

1/Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах:

Бүгд Найрамдах Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд 1955 онд байгуулсан “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т хилийн өртөөг ганцхан Замын-Үүд-Эрээн байхаар тогтоосон бөгөөд хэлэлцээрт гал тэрэгний хөдөлгөөний нөхцөл, ачаа тээврийн төлөвлөгөө тохиролцох журам, ачаа тээвэрлэлт, зорчигч тээвэрлэлт, талуудын хариуцлага зэрэг зарим зарчмын асуудлыг тусгасан боловч хэлэлцээр байгуулагдсанаас хойш 70 орчим жил өнгөрсөн.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрээнд 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн.

Тухайлбал 2004 онд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээрт тусгасан Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Бичигт-Зүүнхатавч хилийн боомтуудыг “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т хэлэлцээрт нэмж тусгах, эдгээр төмөр замын боомтуудын гал тэрэгний хөдөлгөөний нөхцөл, ачаа

тээврийн төлөвлөгөө тохиролцох журам, ачаа тээвэрлэлт зэрэг асуудлыг судалж, хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах хүрээг тодорхойлно.

Улмаар тус асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улстай харилцан тохиролцох, Олон улсын гэрээний тухай хууль тогтоомжид заасан шаардлагтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгын хүрээнд тус зохицуулалтыг тусгалаа.

2/Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд бусад боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалт, хил холболтыг эрчимжүүлэх:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийг 2004 онд байгуулсан. Энэхүү хэлэлцээрийн дагуу Монгол-Хятадын хилийн хэсэгт Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч хилийн боомтуудад төмөр замын хилийн боомт ажиллахаар тогтсон.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас 2012 онд Ганцмод Сэхээ, Зүүнхатавч боомтууд хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан бөгөөд Монгол Улсын төмөр замтай холбогдоход бэлэн болсон. Харин Монгол Улсын талаас хэлэлцээр байгуулагдсанаас хойш төмөр замын хилийн холболт, боомтын бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжээгүй байна. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газар нь дээрх хилийн боомтуудад төмөр замын хилийн боомт ажиллуулах Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ өнөөдрийг хүртэл биелүүлээгүй байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд тус зохицуулалтыг тусгалаа.

3/Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК санхүүжүүлэх:

1.“Шинэ сэргэлтийн бодлого”-д тодорхойлсноор Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлын нэг нь боомтуудын үйл ажиллагааны тогтвортой бус байдал юм.

Экспортын голлох бүтээгдэхүүн болох уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд авто болон төмөр зам, боомтуудын хүчин чадал, гаалиар нэвтрэх тоо, боомт хооронд зарцуулах хугацаа чухал үүрэгтэй. Боомт болон уурхайг холбосон тээврийн сүлжээ нь уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний гарцад шууд нөлөө үзүүлж байна.

Худалдааны голлох боомтуудын нийт импортын бараа, бүтээгдэхүүний 70.1% Улаанбаатар-Замын-Үүд боомтоор хийгдэж байгаа нь боомтууд дээр ачааны

¹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (1992), №1

бөөгнөрөл, төвлөрөл бий болж, экспортын алдагдсан боломжийг нэмэгдүүлж байна. Мөн гадаад, дотоодын зах зээлд холбогдох тээвэр, логиستيкийн хүртээмж, зардал нь эдийн засгийн өсөлтийг хязгаарласан хэвээр байна.

Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын асуудалд ихээхэн ач холбогдол үзүүдэг бөгөөд бодлогын түвшинд анхаарал хандуулдаг байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын XIV таван жилийн төлөвлөгөөнд “Хил залгаа орнуудтай харилцаж буй боомтуудын бүтээн байгуулалт болон хөгжлийг бэхжүүлэх” ажлыг идэвхтэй урагшлуулахаар тусгасны дотор Монгол Улстай хиллэдэг Сэхээ, Ганцмод, Эрээн, Мандал, Зүүнхатавч боомтууд багтсан байна.

2.Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын “санамж бичиг”-ийг 2022 онд үзэглэсэн.

Энэхүү санамж бичгийн хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Чайна энерги” компанийн хооронд Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрийг байгуулсан бөгөөд тус хэлэлцээрт төмөр замыг холбох бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, хил дамнасан төмөр замын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх хэсгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг “Чайна энерги” компани, Монгол Улсын хил доторх хэсгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг “Тавантолгой төмөр зам” ХХК хариуцах нөхцөлөөр хамтран ажиллахаар тохиролцсон.

Тийнхүү дээрх хэлэлцээрийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас Ганцмод боомт хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг Чайна Энержи компани хийж дуусгасан бөгөөд уг төмөр замын 92 хувийг Чайна Энержи компани, 6 хувийг Чалко /Aluminum Corporation of China Limited/, 2 хувийг бусад хуулийн этгээд эзэмшдэг байна.

Харин Монгол Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит “Чайна энерги” компанитай удаа дараа яриа хэлэлцээрийг хийсэн боловч өнөөдрийг хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй бөгөөд хил дамнасан төмөр замын холболтын ажил удааширж, экспортын алдагдсан боломжийг нэмэгдүүлж, тээвэр, логиستيкийн хүртээмж, зардал нь эдийн засгийн өсөлтийг хязгаарласан хэвээр байна.

Иймд Засгийн газар хооронд байгуулсан санамж бичиг болон Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК санхүүжүүлэх нь цаг хугацаа хэмнэх, цаашид экспортын алдагдсан боломжийг нэмэгдүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ гэж үзсэн болно.

4/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод төмөр замын өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компани болон “Эрдэнэс

Тавантолгой” ХК хооронд үе шаттай жил бүр 20 сая тонн хүртэлх нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацааны худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх:

1.Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрт дурдсанаар “Чайна энерги” компани болон “Эрдэнэс Тавантолгой” ХК нь урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэйгээр жил бүр 20 сая тонн нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ байгуулж, хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт болон Тавантолгойн ордын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх явцыг 3 үе шатаар хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- хил дамнасан төмөр зам ашиглалтад орохоос өмнө нүүрс худалдах, худалдан авах урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэй урт хугацаатай гэрээ байгуулах ба “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас жил бүр 5 сая тонн коксжих нүүрс нийлүүлэх;
- хил дамнасан төмөр зам ашиглалтад орсны дараа жил бүр 6 сая тонноос доошгүй коксжих нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулах ба гэрээний хугацаа нь ордын үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэх хүртэл үргэлжлэх;
- талууд 20 сая тонн хатуу коксжих, хагас коксжих, эрчим хүчний, исэлдсэн нүүрсний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх болон нийлүүлэх, худалдан авах гэрээ байгуулна. Тус гэрээний хугацаа эхний ээлжинд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдсэний дараа 10 жил байна.

2.Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор Төмөр замын сүлжээний II дугаар шатанд барьж эхлэх төмөр замын чиглэлд “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийг заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолоор Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай баталж, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төслийг шуурхай эхлүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Энэ хүрээнд нийт 1,005 тэрбум ам.долларын өртөг бүхий Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийг хэрэгжүүлсэн бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажлын явц 87,4%-тай үргэлжилж байгаагаас гадна төмөр замыг байнгын ашиглалтад хүлээн авах шийдвэр гарсан байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар нийт 526,208.25 тонн ачаа тээвэрлэсэн байна. Үүнээс чиглэлээр нь авч үзвэл Тавантолгой - Гашуунсухайт чиглэлд 114,047.85 тонн ачаа тээвэрлэж, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 412,160.4 тонн ачаа тээвэрлэсэн.

Хэдийгээр Тавантолгой-Гашуунсухайт төмөр замыг ашиглалтад оруулсан ч Гашуунсухайт боомт дахь нүүрс хуримтлуулах, хилийн богино тээвэр хийх болон хил нэвтрэх тээврийн ажлыг бүхэлд нь авто замаар гүйцэтгэж байгаа нь тээврийн системийн хүчин чадал, үр ашиг, боомтын хөдөлгөөнд нөлөөлсөөр байна.

Тодруулбал, цаашид Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын холболт хийгдэхгүйд хүрвэл Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын цогцолборын санхүүжүүлт /1,005 тэрбум ам.доллар/-ийн үр өгөөж үнэгүйдэхэд хүрэхээр байна.

Иймд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцсэн гэрээ хэлцлийн хүрээнд барьж, байгуулах шаардлага үүссэн байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтоор дамжин өнгөрөх тээврийг үр ашигтай, байгаль орчинд ээлтэй авто зам, төмөр зам хосолсон логистикийн төвийн үйлчилгээний горимд шилжүүлэх ажлыг хурдасгаснаар логистикийн зардлыг бууруулах, боомтын тээврийн үр ашгийг дээшлүүлэх Тавантолгойн уурхайн олборлолтын талбайн төлөвлөсөн үйлдвэрлэлийн хүчин чадлыг жилд 80 сая тоннд хүргэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дэвсгэрт төмөр замаар бусад бүс нутаг руу тээвэрлэлт хийх боломж бүрдэх бөгөөд бүс нутгийн нүүрсний тээврийн хэрэгцээг хангахад чухал ач холбогдолтой юм.

5/Энэ тогтоолын дагуу байгуулах аливаа гэрээг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөл(off-take)-өөр байгуулахгүй байх:

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх өрөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын 1-д “Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан бөгөөд “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтөйк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх” гэж заасанд нийцүүлэн тус тогтоолын дагуу байгуулах аливаа гэрээг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөл(off-take)-өөр байгуулахгүй байх агуулгыг тусгасан болно. Тус заалтын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын саналыг үндэслэн тогтоолын төсөлд тусгав.

6/Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бусад уул уурхайн болон уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг тээвэрлэх боломжийг бүрдүүлэх:

Тавантолгой орд нь хатуу коксжих, хагас зөөлөн коксжих, эрчим хүчний шинж чанартай нийт 13 төрлийн нүүрсний давхраастай байх бөгөөд боловсруулалт шаардлагагүй, зах зээлд шууд борлуулах боломжтой сайн чанарын хатуу коксжих 3 болон 4-р давхраасуудад голлон олборлолтыг хийсээр ирсэн байна.

Тавантолгой ордын ашиглалтын хугацаанд нийт олборлосон нүүрсний 92.3%-г 3 болон 4-р давхраасаа эзэлж байх бөгөөд тодруулбал, ордын нөөцийн 90 орчим хувийг өнөөдрийг хүртэл сорчлон олборлож иржээ.

Цанхийн баруун болон зүүн уурхайн төхник эдийн засгийн үндэслэлд 2014 болон 2015 онуудад нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж ордын нөөцийг бүрэн ашиглаж, баяжуулсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн байдаг боловч өнөөг хүртэл ашиглалтад ороогүй байна.

Техник эдийн засгийн үндэслэлээр төлөвлөгдсөн баяжуулах үйлдвэр ашиглалтад ороогүйгээс улбаалан ордын нөөцийг иж бүрэн ашиглах, боловсруулалт, баяжуулалт шаардлагатай муу болон дундаж чанарын нүүрсийг олборлох боломжгүй байдалд хүрээд байна. Цаашид ордын нөөцийг сорчлон ашигласнаар Тавантолгойн орд газрын ашиглалтын хугацаа богиносж, эдийн засгийн үр өгөөж буурах эрсдэлд хүрнэ.

Мөн 2018 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан Тавантолгой ордын нөөцийн хэмжээ 6.3 тэрбум тонн бөгөөд үүнээс 2.55 тэрбум тонн буюу 40 хувь нь 1200-аас доош метрийн гүнд, ил аргаар ашиглах боломжгүй юм.

Иймд энэхүү ил аргаар ашиглах боломжгүй хэсэгт нөөцийг далд аргаар буюу лонгволл технологиор олборлох боломжтой нь тодорхойлогдсон бөгөөд баяжуулах үйлдвэр ашиглалтад оруулах, далд аргаар олборлох технологийг нэвтрүүлэх шаардлага үүссэн байна.

Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно.” гэж заасны хүрээнд Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлох, баяжуулах, далд аргаар олборлох технологийг нэвтрүүлэх замаар эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг тусгалаа.

7/Энэ заалтын 3, 4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах:

Нүүрс худалдах, худалдан авах гэрээ болон шаардлагатай бусад хэлцлийг хийхдээ харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэх зарчмыг баримтлах бөгөөд гэрээний нөхцөлийг тодорхойлох, төслийг боловсруулах ажлын хүрээнд санхүү болон хууль эрх зүйн асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэжлийн гадны компаниудаас зөвлөх үйлчилгээ авах шаардлагатай.

Ингэснээр гэрээний төслийг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэх, хамгаалах нөхцөл бүрдэх бөгөөд нийгэм, эдийн засгийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулалтын орчинд эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой гэж үзсэн болно.

Түүнчлэн тогтоолын хэрэгжилтийг танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нийцүүлэн боловсруулсан болно.

8/Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор газар ашиглах асуудлыг шуурхай шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах;

Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр замын газар нь Монгол Улсын Их Хурлын 1996 оны “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 43 дугаар тогтоолын дагуу “Говийн бага дархан цаазат газар”-ын хилийн заагт хамаарах бөгөөд улсын тусгай хамгаалалтад авсан газартай давхцалтай байна.

Иймд төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор газар ашиглах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх шаардлага үүссэн байна.

Тус заалтын Зам, тээврийн хөгжлийн сайдын саналыг үндэслэн тогтоолын төсөлд тусгав.

Тогтоолын төсөл батлагдсанаар Бүгд Найрамдах Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд 1955 онд байгуулсан "Хилийн төмөр замын хэлэлцээр"-ийг шинэчлэн байгуулснаар Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч төмөр замын хилийн боомтуудыг холбох эрх зүйн үндэс бүрдэнэ.

Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам баригдсанаар Тавантолгойн бүлэг ордын үнэ цэнэ өсөх, тээврийн өртөг зардал буурах, уул уурхайн бүтээгдэхүүнийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар тээвэрлэх, төсвийн орлого, валютын нөөцийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Тухайлбал:

- Монгол Улсын дотоодийн нийт бүтээгдэхүүн жил тутам 3.5 тэрбум ам.доллараар өсөх;
- Улсын төсөвт жилд дунджаар 44.8 сая ам.долларын татвар төлөх боломж бүрдэх;
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсад экспортлох нүүрс тээврийн өртөг 42 ам.доллараас 14,6 ам.доллар болж буурах /тонн тутамд тээврийн өртөг 2,8 дахин буурах/;
- Зүүн Азийн зах зээлд Монголын нүүрсний экспортын эзлэх хувь өнөөгийн байдлаар 10.5% байгааг нэмэгдүүлж, 30.5%-д хүргэх;
- Монгол Улсын экспортын гуравны нэгийг дангаар бүрдүүлдэг нүүрсний салбарын экспортын орлого жилд дунджаар 2.61 тэрбум ам.доллар байгааг 2.8 дахин нэмэгдүүлж, 7.4 тэрбум ам.долларт хүргэх боломж бүрдэх;
- Төмөр замын тээвэр ашиглалтын зардлын тонн/км тутамд ноогдох өртгийг авто замын тээвэр ашиглалтын зардлын өртөгтэй харьцуулахад 29%-иар багасах;
- тогтмол ажлын байрыг нэмэгдүүлэх;
- малын бэлчээр сүйдэх, хөрс, агаарын бохирдол зэрэг байгаль оринл 74%-иар буурах.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ...сарын ...өдөр

Улаанбаатар хот

Дугаар

МОНГОЛ-ХЯТАДЫН 1955 ОНЫ “ХИЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ХЭЛЭЛЦЭЭР” БОЛОН “ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙГООР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэх, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах;

2/Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд бусад боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалт, хил холболтыг эрчимжүүлэх;

3/Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зураг төсөл, төхник, эдийн засгийн үндэслэлийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК санхүүжүүлэх;

4/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод төмөр замын өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компани болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд үе шаттай жил бүр 20 сая тонн хүртэлх нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацааны худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх;

5/Энэ тогтоолын дагуу байгуулах аливаа гэрээг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөл(off-take)-өөр байгуулахгүй байх;

6/Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бусад уул уурхайн болон уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг тээвэрлэх боломжийг бүрдүүлэх;

7/Энэ заалтын 3, 4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах;

8/Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор газар ашиглах асуудлыг шуурхай шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын 2023 10 дугаар сард багтаан Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

БИДНИЙ ТУХАЙ ▾ УЙЛАЖИЛЛАГАА ▾ ХАРЬЯА БАЙГУУЛАГУУД ▾ ЭРХ ЗҮЙН АКТ ▾ ХУУЛИЙН ТӨСӨЛ ▾ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ▾ ИЛТОД БАЙДАЛ ▾ ШИЛЭН ДАНС



МОНГОЛ-ХЯТАДЫН 1955 ОНЫ "ХИЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ХЭЛЭЛЦЭЭР" БОЛОН "ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД" ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙГООР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

МОНГОЛ-ХЯТАДЫН 1955 ОНЫ "ХИЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ХЭЛЭЛЦЭЭР" БОЛОН "ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД" ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙГООР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Нийтлэгдсэн огноо: 2023-06-20

Хуулийн төсөлд санал өгөх

МОНГОЛ-ХЯТАДЫН 1955 ОНЫ "ХИЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ХЭЛЭЛЦЭЭР" БОЛОН "ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД" ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙГООР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Хэвсралт файл

Төслийн файл

[Харах](#)

Үзэл бэримтлэл

[Харах](#)

Дэлгэрэнгүй танилцуулга

[Харах](#)

Товч танилцуулга

[Харах](#)